

# “ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН: ТОГТВОРТОЙ БАЙДАЛ”

## Олон улсын бага хурал Оролцогчдын танилцуулга

### НЭЭЛТ

#### Н.Баяртсайхан

Ерөнхийлөгч,  
Монголбанк



#### Ажлын туршлага:

- Монголбанкны Ерөнхийлөгч /2016 оноос/
- Монголын Хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбооны хяналтын зөвлөлийн дарга /2014-2016/
- Монголын Хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбооны ерөнхийлөгч /2002-2014/
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайд /2006-2007/
- Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга /2000-2004/
- Улсын Их Хурлын Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга /1993-1995/
- Монгол Улсын Их Хурлын гишүүн /1992-2008/
- МАХН-ын Төв хорооны дэргэдэх Намын дээд сургуульд багш /1982-1989/

#### Эрдмийн зэрэг:

- ОХУ, Байгалийн Их сургууль, Эдийн засгийн хүндэт доктор
- ОХУ, Москва хот, Төрийн Удирдлагын академи, Эдийн засгийн профессор
- Монгол Улсын Шинжлэх ухааны академийн гишүүн

#### Боловсрол, мэргэжил:

- ОХУ, Москва хотын Төрийн Удирдлагын академи, Эдийн засгийн шинжлэх ухааны доктор /Sc.D./
- ОХУ, Москва хотын Төрийн Удирдлагын академи, Эдийн засгийн ухааны доктор /Ph.D./
- ОХУ, Эрхүү хотын Улс, Ардын Аж Ахуйн Дээд Сургууль, Хөдөлмөрийн эдийн засагч

### НЭЭЛТ

#### Л.Оюун-Эрдэнэ

ЗГХЭГ-ын дарга,  
Засгийн газар



#### Ажлын туршлага:

- 2012 он Монгол Ардын Намын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч
- 2011 он Монгол Ардын Намын Нарийн бичгийн дарга
- 2010-2014 он Нийгмийн Ардчилал Монголын Залуучуудын холбооны Ерөнхийлөгч
- 2009 онд Монгол Ардын Намын Удирдах Зөвлөлийн Хэрэг эрхлэх газрын дарга
- 2008 онд Нийслэлийн Баянзүрх дүүрэгт Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
- 2006 он “Дэлхийн Зөн Монгол” ОУБ-ын Бүсийн Захирал
- 2002 он “Дэлхийн Зөн Монгол” ОУБ-ын Хан Хэнтий нутгийн Хөгжлийн хөтөлбөрийн удирдагч
- 2001 он Хэнтий аймгийн Бэрх хотын захирагчийн албанд Тамгын газрын дарга

#### Боловсрол, мэргэжил:

- 2015 онд АНУ-ын Харвардын Их сургуулийг Төрийн удирдлагын магистр
- 2011 онд МУИС-ийн Нийгмийн Шинжлэх Ухааны сургуулийг улс төр судлаач мэргэжлээр
- 2008 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг Эрх зүйч мэргэжлээр
- 2005 онд Австралийн Мельбурний Их сургуулийг Олон улсын төслийн менежментийн хөтөлбөр
- 2001 онд Бэрс дээд сургууль сэтгүүлч мэргэжлээр
- 1998 онд Хэнтий аймгийн Ерөнхий боловсролын сургууль

## НЭЭЛТ

### Руфат Алимарданов

Суурин төлөөлөгч,  
ОУСК



#### Ажлын туршлага:

- Ноён Руфат Алимарданов нь анх АНУ-ын Вашингтон хотноо ОУСК-д 1997 онд орсон. Тэрээр үйлдвэрлэл, үйлчилгээ, санхүүгийн зах зээлийг голчилж олон газарт ажилласан туршлагатай бөгөөд 2004 онд Москва хотноо шилжиж, ОУСК-ийн Зүүн Европын орнуудын үйлдвэрлэл, үйлчилгээ (одоо хөдөө аж ахуйн үйлдвэрлэл), газрын тос, хий, уул уурхайн салбарын багуудыг удирдаж ажилласан. 2011 онд ноён Руфат нь ОУСБ-ын дэд бүс үйл ажиллагааг хянахаар Украин, Беларусыг хариуцсан Менежерээр томилогдсон. Ноён Руфат нь Киевт ажиллаж байхдаа Украин дахь хувьчлалын зөвлөлийн идэвхтэй гишүүн байсан бөгөөд Беларусь, Украин уруу хөрөнгө оруулалт татах, хөтөлбөрийг шинэчлэхэд олон баг хамт орж ажилласан туршлагатай. Ноён Руфат нь 2017 онд Истанбулын Иргэний нийгмийн байгууллагад Европ, Ойрхи Дорнод, Хойд Африк бүсийн чанаргүй зээлийн асуудлыг хариуцаж эхэлсэн. ОУСК-д ажиллахаас өмнө Азербайджан, Орос, Турк улсуудын арилжааны банк, АНУ-д харилцаа холбооны салбарт ажиллаж байсан.
- Ноён Руфат нь МВА болон CFA зэрэгтэй бөгөөд АНУ-ын Остин-д Техасын Христийн их сургууль, Техасын их сургуульд суралцаж төгссөн.

## Салбар хуралдаан 1

## Хөрөнгө оруулалтын орчин: Сорилт ба шийдэл

### Илтгэгч:

“Бодит болон санхүүгийн салбар дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын үр өгөөж”

### Д.Ган-Очир

Ерөнхий эдийн засагч,  
Монголбанк



#### Ажлын туршлага:

- Монголбанк, Ерөнхий эдийн засагч /2019-одоог хүртэл/
- Монголбанк, Судалгаа, статистикийн газрын захирал /2016-2019/
- Монголбанкны Ерөнхий эдийн засагч - Ерөнхийлөгчийн зөвлөх /2016/
- Австралийн Үндэсний их сургууль, Төрийн удирдлагын Кровфорд сургууль, Хэрэглээний динамик эдийн засаг, Зардал үр ашгийн шинжилгээ болон Олон улсын эдийн засаг хичээлүүд, Семинарын багш /2015-2016/
- Монголбанкны Ерөнхийлөгчийн зөвлөх бөгөөд Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн ажлын албаны дарга /2012-2013/
- Монголбанк, Мөнгөний бодлого, судалгааны газар, Эдийн засагч /2005-2012/
- Монгол Улсын их сургууль, Эдийн засгийн сургууль, Лекц, семинарын цагийн багш /2005-2009/

#### Боловсрол, мэргэжил:

- Австрали улс, Австралийн Үндэсний их сургууль, Төрийн удирдлагын Кровфорд сургууль, Эдийн засгийн ухааны доктор /PhD/
- Австрали улс, Австралийн Үндэсний их сургууль, Төрийн удирдлагын Кровфорд сургууль, Олон улсын болон хөгжлийн эдийн засгийн магистр
- Монгол Улсын их сургууль, Эдийн засгийн сургууль, Газрын эдийн засаг-эрх зүй, Эдийн засгийн ухааны магистр Монгол Улсын их сургууль, Эдийн засгийн сургууль, Эдийн засгийн ухааны бакалавр

## Илтгэгч:

“Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчны шинэтгэлийн зураглал, зөвлөмж”

### Завиер Форнерис

Ахлах мэргэжилтэн,  
Дэлхийн банк групп



### Ажлын туршлага:

- Завиер Форнерис нь Дэлхийн Банк группын Худалдаа болон өрсөлдөх чадварын газрын Хөрөнгө оруулалтын орчны хэлтсийн Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн юм. Тэрээр Хойд Каролины Их сургууль (UNC-Chapel Hill)-д Бизнесийн удирдалын магистрын зэрэг, мөн Франц дахь Европын тэргүүлэх хуулийн сургууль (Aix-en-Provence, France)-д хууль зүйн ухааны хосолсон зэрэг (Хууль зүйн магистр болон Шүүхийн ухааны докторын зэрэгтэй дүйцэх) хамгаалсан. Тэрээр хөгжиж буй орнуудад хөрөнгө оруулалт, нэн ялангуяа гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах, нэгэнт орж ирсэн хөрөнгө оруулалтыг хадгалж үлдэхэд чиглэсэн эдийн засаг, бодлого, зохицуулалтын шинэтгэлийн асуудлаар зөвлөгөө өгөх чиглэлээр 20 гаруй жил ажилласан туршлагатай. Ноён Форнерис нь Дэлхийн банк группын үйл ажиллагаагаа явуулдаг бүхий л бүс нутгууд дахь 50 орчим оронд ажилласан. Тэрээр одоо тус банкны Зүүн Ази, Номхон далайн бүсийн Олон улсын хөрөнгө оруулалтын орчны асуудал хариуцсан багийн зохицуулагчаар ажилладаг бөгөөд тус банкны Хөрөнгө оруулалтыг хамгаалах, хадгалж үлдэх үйл ажиллагааг ахалж байна. Дэлхийн банк группэд орохоосоо өмнө ноён Форнерис нь төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын худалдаа, хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэшсэн хуульчаар, мөн хөгжиж буй орнуудад хууль эрх зүйн чадавхийг бүрдүүлэх, сургалтын чиглэлээр тус тус ажиллаж байсан.

## Модератор:

### С.Дэмбэрэл

ЭЗССХ-ийн захирал,  
Монголбанк



### Ажлын туршлага:

- Монгол Улсын Их Хурлын гишүүн (2012-2016)
- МҮХАҮТ-ын дарга, гүйцэтгэх захирал (1997 оноос хойш)
- Засгийн газар, хувийн хэвшлийн зөвлөлдөх хорооны дарга (2005 оноос хойш)
- Монгол Улсын Ерөнхий сайдын эдийн засгийн зөвлөх (2000-2004) / (2004-2008) / (2008-2012)
- Үндэсний Арбитрын шүүхийн дарга (2000 оноос хойш)
- Тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөлийн дарга / NBCSD (1998 оноос хойш).
- Зах зээлийн судалгааны хүрээлэнгийн ерөнхий захирал / MRI (1993-2000)
- Судлаач, MRI-ийн ахлах судлаач (1990-1993)
- Эдийн засгийн дээд сургуулийн судлаач (1984-1990)
- “Комплекс импорт” гадаад худалдааны корпорацийн нягтлан бодогч, ахлах нягтлан бодогч (1981-1984)

### Боловсрол, мэргэжил:

- МУИС-ийн Эдийн засгийн факультет (1981-1984)

## Хэлэлцүүлэгт оролцогчид:

**Б.Лхагвасүрэн** Монголбанкны дэд ерөнхийлөгч

**Х.Булгантуяа** Сангийн дэд сайд

**Т.Дүүрэн** Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрлэлийн танхимын гүйцэтгэх захирал

**Ц.Түмэнцогт** Монголын бизнесийн зөвлөлийн Удирдах зөвлөлийн гишүүн

**Н.Энхбаяр** МУ-ын Ерөнхий сайдын эдийн засгийн бодлогын зөвлөх асан

## Илтгэгч:

## “Зөвшөөрлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга”

**Ц.Мөнхбаяр**

Ахлах зөвлөх,  
УИХ-ын ЭЗБХороо

**Ажлын туршлага:**

- Цэдэвсүрэнгийн Мөнхбаяр нь УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны Ажлын албаны ахлах зөвлөхөөр 2019 оны 3 сараас, Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны гишүүнээр 2018 оны 5-р сараас тус тус ажиллаж байна. Үүнээс өмнө УИХ-ын даргын эдийн засгийн бодлогын зөвлөх, Монголбанкны Валютын газарт ахлах эдийн засагч, хэлтсийн захирал, Монголбанкны Ерөнхийлөгчийн зөвлөх бөгөөд Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга, Судалгаа, статистикийн газрын захирал, Сангийн яаманд мэргэжилтнээр тус тус ажиллаж байсан. Ц.Мөнхбаяр нь МУИС-ийг эдийн засгийн ухааны бакалавр, Япон Улсын Бодлого, судлалын үндэсний хүрээлэнг Төрийн эдийн засгийн бодлогын магистр, Австралийн Үндэсний Их Сургуулийг санхүүгийн магистр зэргээр тус тус төгссөн.

## Илтгэгч:

## “Хөрөнгө оруулалтын хамгаалал, үйлчилгээ”

**Л.Мөнхбат**

ХОБЗ-ын газрын дарга,  
ҮХГГазар

**Ажлын туршлага:**

- Үндэсний хөгжлийн газар нь Монгол Улсын эдийн засаг, нийгэм, хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах үндсэн зорилготой бөгөөд Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогын хэлтэс нь хөрөнгө оруулалтын бодлого, хөтөлбөр боловсруулах, хөрөнгө оруулалтын талаарх үндэсний хууль тогтоомж, шийдвэр болон олон улсын улсын гэрээ, конвенцийн хэрэгжилтийг хангах, мөн хөрөнгө оруулагчдад татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх хүрээнд хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах, тогтворжуулах гэрчилгээ олгох, түүнчлэн төр-хувийн хэвшлийн түншлэлийн талаар бодлого боловсруулах, концессын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэгтэй юм. Лхагваа овогтой Мөнхбат нь магистрын зэрэгтэй бөгөөд олон нийтийн харилцаа, олон улсын бизнесийн чиглэлээр тус тус мэргэшсэн, ОХУ, ХБНГУ, АНУ-д боловсрол эзэмшсэн. Орос, герман хэлтэй, англи хэлний мэдлэгтэй. Боловсрол, шинжлэх ухаан, худалдаа, хөдөө аж ахуй, түүхий эдийн болон санхүүгийн зах зээлийн салбарын зохицуулах чиг үүргийн байгууллагуудад ажилласан туршлагатай.

## Илтгэгч:

## “Төлбөрийн чадваргүйдэл: Шинэ зохицуулалт”

**Жин Чанг Лай**

Бүс нутаг хариуцсан тэргүүн,  
Дэлхийн банк групп

**Ажлын туршлага:**

- Жинчанг Лай нь Дэлхийн банкны бүлгийн гишүүн байгууллага болох Олон улсын санхүүгийн корпорацийн (ОУСК) Зүүн Ази номхон далайн бүс нутгийн Санхүүгийн дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөрийн тэргүүнээр ажилладаг. Өмнө нь тэрээр Хятад Улсын Ченгду дахь ОУСК-ийн оффисийн тэргүүн, Санхүүгийн салбарийн хөгжил ба бодлого хариуцсан хөтөлбөрийн менежер, Хятад болон Монгол улс дахь ОУСК-ийн Зөвлөгөө өгөх Үйлчилгээний Санхүүгийн Хүртээмж Хөтөлбөрийн Менежерээр тус тус ажиллаж байсан. 2002 оноос өмнө Жинчанг нь Африкийн хөгжлийн банкны Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг удирдаж, Ахлах эдийн засагч, Хөтөлбөрийн ерөнхий зохицуулагч, Дэд ерөнхийлөгчийн тусгай зөвлөх, Хөрөнгө оруулалтын ахлах мэргэжилтэн зэрэг ажлуудыг 1992 оноос 2000 оны хооронд хийж байсан. Мөн тэрээр нэгэн банк болон Пан-Африк ЖДБ-ийг дэмжих хөтөлбөрийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байв. 1992 оноос өмнө тэрээр БНХАУ-ын Ардын банкинд эдийн засагч мөн хэлтэсийн даргаар ажиллаж байсан байна. Жинчанг нь санхүүгийн үйлчилгээ, хувийн хэвшлийн хөрөнгө

оруулалт, бодлогын шинэчлэл зэрэг чиглэлээр Ази болон Африкийн олон улс орнуудад ажиллаж байсан 30 гаруй жилийн туршлагатай юм. Жинчанг нь 2011-2016 онуудын хооронд Хятадын үндэсний бичил санхүүжилтын институтын ТУЗ-ийн гишүүн байсан. Сүүлийн жилүүдэд Ази номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны санхүүгийн салбарын дэд бүтцийг хөгжүүлэх, худалдаа, нийлүүлэлтийн сүлжээ, FinTech зах зээлийн хөгжлийг дэмжих чиглэлүүдээр идэвхтэй ажиллаж байна. Тэрээр Ази номхон далайн улс орнуудын санхүүгийн салбарын дэд бүтцийг хөгжүүлэх холбооны тэргүүнүүдийн нэг билээ.

## Модератор:

**Б.Батдаваа**  
ССГ-ын захирал,  
Монголбанк



## Ажлын туршлага:

- Монголбанк, Судалгаа, статистикийн газрын захирал /2019-одоог хүртэл/
- Монголбанк, Зах зээлийн газрын захирал /2016-2017/
- Монголбанк, Зах зээлийн газрын Гадаад валютын улсын нөөцийн удирдлагын хэлтсийн захирал /2016-2016/
- Монголбанк, Валют, эдийн засгийн газрын Санхүүгийн зах зээлийн хэлтсийн ахлах дилер /2011-2013/
- Монголбанк, Валютын газрын эдийн засагч, дилер /2008-2011/
- Монголбанк, Төлбөр тооцоо, бүртгэлийн газрын нягтлан бодогч, эдийн засагч /2007-2008/

## Боловсрол, мэргэжил:

- Люксембург, Люксембургийн их сургууль, Люксембургийн санхүүгийн сургууль, Банк, санхүүгийн шинжлэх ухааны магистр
- Хятад, Тайвань, Минг Чуаны их сургууль, Бизнесийн удирдлагын баклавр

## Хэлэлцүүлэгт оролцогчид:

- Д.Жигжидмаа** Дэлхийн Банк Групп, Олон улсын санхүүгийн корпорацийн ахлах мэргэжилтэн
- Б.Баасандорж** Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга
- Л.Ариунболд** Барилгын үндэсний ассоциацийн дэд ерөнхийлөгч
- Д.Золжаргал** “ДиБи энд ЖиТиЭс” Нөхөрлөлийн гүйцэтгэх захирал
- Ц.Эрдэнэбат** “Тэрэгэ Системс” ХХК-ны үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирал

## Илтгэгч:

## “Дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагчдын хоорондын хамтын ажиллагаа, холбоосын сувгийг хөгжүүлэх”

## Виллем Доув

Тэргүүлэх мэргэжилтэн,  
Дэлхийн банк групп



## Ажлын туршлага:

- Ноён Вим Доуэ нь гадаадын шууд хөрөнгө оруулалт, хувийн салбарын хөгжлийн чиглэлээр 20 гаруй жил ажиллаж байна.

Тэрээр Дэлхийн банк групп, Зүүн Европ, Зүүн Өмнөд Ази, Өмнөд Ази, Ойрхи Дорнод, Африкийн бүс нутгийн 25 гаруй оронд хөрөнгө оруулалтын орчны шинэчлэл, ГШХО-ыг дэмжих бодлого, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг ахлан ажилласан бөгөөд одоогийн байдлаар Вена хотод байрладаг Дэлхийн Банкны Группын Глобал практик төвийн Худалдаа, Хөрөнгө оруулалт ба өрсөлдөх чадвар (PIC) - чиглэлээр хувийн хэвшил хариуцсан ахлах шинжээч, Зүүн Европ ба Төв Азийн Хөрөнгө оруулалтын бодлого, Дэмжлэг сурталчилгаа, үйлчилгээний хөтөлбөрийг удирдаж ГШХО хэлхээ холбоо болон түүний үр өгөөжийн хөтөлбөрийг хариуцсан ахлах шинжээчээр тус тус ажиллаж байна.

Ноён Вим 2010-2015 онд Кени улсын Найроби хотод Африкт аж үйлдвэрийн зөвлөх үйлчилгээнд зориулагдсан ОУСК-ийн Хөрөнгө оруулалтын орчныг тэлэх, хэрэгжүүлэх ажлыг удирдан ажилласан. Үүнээс өмнө АНУ-ын Вашингтон ДС-д Хөрөнгө оруулалтын орчны хэлтэст дэлхийн хэмжээнд хөрөнгө оруулалтын орчин, хөрөнгө оруулалтыг дэмжих өргөн цар хүрээтэй төслүүдийг боловсруулж, хэрэгжүүлж байсан.

2005 онд Ноён Вим АНУ-ын Вашингтон ДС дахь Дэлхийн Банк групп-д орохоос өмнө Брюссель хотод “PricewaterhouseCoopers консалтинг”-ийн корпорацийн байршлын стратегийн менежментийн зөвлөхөөр, мөн Нидерландын Утрехт хотод байрлах “Эрнст ба Янгийн Олон улсын локашон”-д зөвлөх үйлчилгээнд ажиллаж байсан.

Тэрээр хуримтлуулсан туршилгаараа ОУ-ын корпорацуудын удирдах албан тушаалтан мэргэжилтнүүдэд олон янзын чиглэлээр байршлын стратеги, хөрөнгө оруулалтын шийдвэрийн талаар, мөн гадаадын хөрөнгө оруулалтын өрсөлдөх чадварын талаар засгийн газарт зөвлөгөө өгч байсан юм.

Ноён Вим нь дэлхийн үнэ цэнийн сүлжээ, гадаадын шууд хөрөнгө оруулалтын бодлогын чиглэлээр өндөр түвшний хурал чуулганд тогтмол илтгэгч, панелистаар оролцдог бөгөөд саяхан Дубайд зохион байгуулагдсан Дэлхийн хөрөнгө оруулалтын бага хуралд “Дэлхийн үнэ цэнийн сүлжээ - Өсөлт ба Хэлхээ холбоосоор дамжуулсан Бизнес эрхлэлт” салбар хуралдааныг даргалж оролцсон.

## Илтгэгч:

## “Гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бодит алхмууд”

## Б.Солонгоо

УЗ-ийн гишүүн,  
Монголын бизнесийн зөвлөл



## Ажлын туршлага:

- “Авинекс түншлэл” /ХХН/- үүсгэн байгуулагч.

2019 оны 1 сарын 16-нд Б.Солонгоо нь Монголын Бизнесийн Зөвлөлийн гүйцэтгэх хорооны гишүүн, Татвар, Хууль эрх зүй, Ёс зүйн ажлын хэсгийн даргаар томилогдсон.

Б.Солонгоо нь “Авинекс түншлэл” /ХХН/-ийн үүсгэн байгуулагч, компани, худалдааны эрх зүйгээр мэргэшсэн бөгөөд үүний дотор банк, санхүү, уул уурхай, байгалийн баялаг болон зохицуулалтын чиглэлээр дагнан ажилладаг. Тэрээр гүйлгээний болон орон нутгийн зөвлөхийн хувиар өндөр зэрэглэлийн, хил дамнасан санхүүжилт, хувьцааны гүйлгээний асуудлаар үйлчлүүлэгчиддээ зөвлөгөө өгч байсан туршлагатай.

Мөн Б.Солонгоо нь тус фирмийг хамтран үүсгэн байгуулахаасаа өмнө ОУ-ын хуулийн фирмийн УБ дахь салбар, цөм болсон Монголын компанид ажиллаж байсан. Тэрээр Монголын Хуульчдын холбооны гишүүн бөгөөд Монголын

мэргэшсэн хуульчдад зориулсан хууль, эрх зүйн боловсрол олгох сургалтад багшилдаг.

Б.Солонгоо нь АНУ-ын Нью-Йорк, Англи, Уэльс мужуудад хууль эрх зүйн чиглэлээр ажиллах эрхтэй Монголын Бизнесийн Зөвлөлийн Татвар, Хууль, Ёс зүйн ажлын хэсгийн дарга юм.

Б.Солонгоог 2018 оны “Legal500”- дугаартаа “Дараа үеийн хуульч” гэж онцлон нэрлэсэн юм.

## Модератор:

**Б.Түвшинтөгс**  
Захирал,  
ЭЗСЭШХүрээлэн



## Ажлын туршлага:

- Батдэлгэрийн Түвшинтөгс (Phd) нь МУИС-ийн Эдийн засгийн дэд профессор, Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захиралаар ажиллаж байна юм. Тэрээр эдгээр байгууллагад макро эдийн засгийн бодлого, нийгмийн асуудлын талаархи бодлогын шинжилгээ болон уул уурхай, дэд бүтцийн томоохон төслүүдийн эдийн засагт үзүүлэх нөлөөллийн шинжилгээний судалгааны багуудыг удирддаг. Түүний мэргэшсэн чиглэл нь макро эдийн засгийн бодлого, мөнгөний эдийн засаг, олон улсын эдийн засаг, уул уурхайн төслүүдийн эдийн засагт үзүүлэх нөлөөллийн үнэлгээ зэрэг юм.

## Боловсрол, мэргэжил:

- Доктор (Ph.D., Экономикс), Бостоны их сургууль, АНУ, 2009
- Магистр (М.А., Экономикс), Манчестерын их сургууль, ИБУИНВУ, 1999
- Бакалавр(В.А., Экономикс), МУИС, Монгол улс, 1997

## Хэлэлцүүлэгт оролцогчид:

- Тацуяа Хамада** “Мобиком Корпораци” ХХК-ны ерөнхий захирал
- Б.Самади** “Скай Хайпермаркет” ХХК-ны гүйцэтгэх захирал
- М.Мандхай** Сүү ХК-ны гүйцэтгэх захирал
- С.Цэнгэл** “М-Си-Эс” Группын Хөрөнгө оруулалт хариуцсан захирал
- С.Бат-Эрдэнэ** Орамталл ХХК-ны ерөнхий захирал
- Ч.Ганцэцэг** “Ханбогд кашмер” ХХК-ны гүйцэтгэх захирал

## Модератор:

**Ц.Түмэнцогт**

УЗ-ийн гишүүн,

Монголын бизнесийн зөвлөл



## Ажлын туршлага:

- Ц.Түмэнцогт нь Эрдэнэс Оюу Толгой ХХК-ийн гүйцэтгэх захирлаар ажилладаг бөгөөд 2018 оны 6 сарын 5-ны өдөр Оюу Толгой ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдсон.

Тэрээр стратегийн ач холбогдол бүхий уул уурхайн хөрөнгө (Тавантолгой нүүрсний орд, Оюу Толгойн зэс, алт (34%), Багануур, Шивээ овоо гэх мэт нүүрсний ордууд, Гашуунсухайт чиглэлийн хатуу хучилттай зам, ураны хөрөнгө зэрэг)-ийг удирдан зохион байгуулдаг Монголын хамгийн том төрийн холдинг компани болох Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирлаар 2016 оны 9 дүгээр сараас хойш ажиллаж байв.

Үүнээс өмнө 2011-2016 онд Монгол дахь “Женерал электрик”-ийн Ерөнхий төлөөлөгч ба Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан. Түүний үүрэг бол цахилгаан эрчим хүч, сэргээгдэх эрчим хүч, төмөр зам, агаарын тээвэр, уул уурхай, эрүүл мэндийн салбарт ЖЭ бүтээгдэхүүний маркетинг хийх, санхүүжилтийн шийдэл зохион байгуулах, бизнесийн хөгжил, үйлчлүүлэгчид болон Засгийн газартай харилцаа холбоо тогтоох, ЖЭ бизнесийг Монголд дэмжих түншлэл байгуулах зэрэг ажлуудыг багтаасан болно.

Мөн тэрээр Монголын CEO клуб, Монголын бизнесийн зөвлөл, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим зэрэг байгууллагуудын ТУЗ-ийн гишүүнээр ажилладаг.

Ц.Түмэнцогт нь бол төслийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын зээл, дэд бүтэц (эрчим хүч, сэргээгдэх эрчим хүч, төмөр зам, ус) чиглэлээр менежментийн туршлагатай бизнесийн зөвлөх юм.

Тэрээр Түлш, эрчим хүчний сайдын зөвлөхөөр, Эрчим хүчний зохицуулах хороонд комиссараар ажиллаж байсан. Мөн Дэд бүтцийн яам, Түлш, эрчим хүчний яам болон Төрийн өмчийн хороонд төслийн менежмент, төслийн санхүү, эрчим хүчний бодлого, эрчим хүчний салбарын зохицуулалт, бүс нутгийн эрчим хүчний хамтын ажиллагаа, сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний үр ашиг, нүүрстөрөгчийн санхүү, агаарын бохирдол, хотын дэд бүтэц зэрэг чиглэлээр ажиллаж байсан.

Ц.Түмэнцогт нь Москвагийн Эрчим Хүчний Институтийн цахилгааны инженерийн магистр, Индиана их сургуулийн Төрийн захиргааны магистр зэрэгтэй.

## Хэлэлцүүлэгт оролцогчид:

**Дэйв Воусэн** Австрали улсаас Монгол улсад суугаа элчин сайд

**Майкл С.Клечески** Америкийн Нэгдсэн улсаас Монгол улсад суугаа элчин сайд

**Филип Малоне** ИБУИНВУ-аас Монгол улсад суугаа элчин сайд

**Азизов Искандер Кубарович** Оросын Холбооны улсаас Монгол улсад суугаа элчин сайд

**Такаока Масато** Япон улсаас Монгол улсад суугаа элчин сайд

**Сон Шюжюн** БНХАУ-аас Монгол улсад суугаа элчин сайдын яамны Худалдаа хариуцсан Консул



## Хаалт

### Б.Баярсайхан

Дарга,  
Үндэсний хөгжлийн газар



#### Ажлын туршлага:

- Үндэсний хөгжлийн газрын дарга Банзрагчийн Баярсайхан. Тэрээр Үндэсний хөгжлийн газрын даргаар томилогдохоос өмнө, Монгол Улсын Их Хурлын даргын Монгол-Японы Эдийн Засгийн Түншлэлийн хэлэлцээр хариуцсан орон тооны бус зөвлөх, мөн гадаад бодлогын зөвлөхөөр тус тус ажиллаж байсан. Б.Баярсайхан нь Япон Улсын Токио хотод “JPMorgan Securities Japan”, Япон Улсын “Credit Saison” группийн “Saison Information Systems” зэрэг компаниудад, мөн Монгол Улсын банк, санхүүгийн салбарт ажиллаж байсан бөгөөд гадаад, дотоодын санхүүгийн байгууллагууд, хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллах, санхүүгийн зөвлөгөө өгөх зэрэгт туршлагатай нэгэн юм. Мөн тэрээр Япон Улсын Ниппон Инженерийн Коллежийг Мэдээлэл технологийн чиглэлээр дүүргэж, Монгол Улсын Техникийн Их Сургуулийн Цахилгаан систем автоматжуулалтын чиглэлээр бакалавр зэрэг, Монгол Улсын Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийн Бизнесийн Удирдлагын чиглэлээр магистрын зэргүүдийг тус тус хамгаалсан. Одоо тэрээр Монгол Улсын Их Сургуулийн Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуулийн Төрийн захиргааны удирдлагын чиглэлээр докторын зэрэг хамгаалахад хөгжлийн бодлого, төлөвлөлтийн чиглэлээр судалгаа, шинжилгээ хийж байгаа юм.

## Хаалт

### Б.Лхагвасүрэн

Дэд ерөнхийлөгч,  
Монголбанк



#### Ажлын туршлага:

- Монголбанкны Дэд Ерөнхийлөгч /2016 оноос/
- Хадгаламжийн Даатгалын Корпораци, Гүйцэтгэх захирал
- Монголын Банкны Холбоо, Дэд Ерөнхийлөгч /2013-2016/
- Монголбанк, Хяналт шалгалтын газрын захирал /2009-2013/
- Монголбанк, Бүртгэл тооцоо, мэдээлэл технологийн газрын захирал /2001-2009/
- Санхүүгийн Зохицуулах Хорооны гишүүн /2002/
- Монголбанкны Ерөнхийлөгчийн зөвлөх, Монголбанк /2000-2001/
- Дэлхийн банк, Вашингтон дахь Зүүн хойд Ази, Номхон далайн орнуудын санхүүгийн сектор, Зөвлөх /1999-2000/
- Монголбанк, Хяналт шалгалтын газрын захирал /1997-1998/
- Монголбанк, Мөнгөний бодлогын газар, Ахлах эдийн засагч /1994-1997/
- Шинжлэх Ухааны Эдийн Засгийн Хүрээлэн, Эрдэм шинжилгээний ажилтан /1989-1994/

#### Боловсрол, мэргэжил:

- АНУ, Колумбын Их Сургууль, Олон улсын эдийн засгийн харилцааны магистр
- Монгол Улсын Их Сургууль, Эдийн засгийн сургууль, Эдийн засагч, Бакалавр